



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 07 сарын 10 өдөр

Дугаар А/243

Улаанбаатар хот

**Сонгинохайрхан дүүргийн Худалдан
авах ажиллагааны албаны балансаас
хөрөнгө шилжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.7, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 1,980,000.0 /Нэг сая есөн зуун наян мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын балансад шилжүүлж данс бүртгэлээсээ хасахыг Сонгинохайрхан дүүргийн Худалдан авах ажиллагааны алба /Х.Батхүү/-нд зөвшөөрсүгэй.


2. Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бүртгэж авахыг Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар /Д.Төмөрбаатар/-т даалгасугай.

3. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар /Д.Төмөрбаатар/, Сонгинохайрхан дүүргийн Худалдан авах ажиллагааны алба /Х.Батхүү/-нд, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс /М.Энхболд/-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
 газрын даргын 2019 оны 07 сарын
 10 өдрийн 1/243 дугаар тушаалын хавсралт



Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Сонгинохайрхан дүүргийн Худалдан авах ажиллагааны газар

| № | Эд хөрөнгийн нэр | Ашиглалтанд орсон он | Хэмжих нэгж | Тоо ширхэг | Нэгж үнэ | Бүгд үнэ | Хуримтлагдсан элэгдэл | Үлдэгдэл өртөг | Хөрөнгө хүлээн авагч байгууллага |
|------------------------------|-------------------------------|----------------------|-------------|------------|------------|---------------------|-----------------------|----------------|---|
| 1 | Компьютер /Dell optiplex 390/ | 2013 | ш | 5 | 935,000.00 | 1,490,500.00 | 1,490,500.00 | - | Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар |
| 2 | Компьютер /Dell 3010/ | 2013 | ш | 1 | 945,000.00 | 489,500.00 | 489,500.00 | - | |
| Машин тоног төхөөрөмжийн дүн | | | | | | 1,980,000.00 | 1,980,000.00 | - | |
| Нийт дүн | | | | | | 1,980,000.00 | 1,980,000.00 | - | |